



Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагнал

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний
Менежер
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батчулууны Амаржаргал

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
amarjargal.batchuluun@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс
Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексийг (Шинэчилсэн Хувилбар) (“Кодекс”) баталж, мөн Монголын Хөрөнгийн Бирж (“МХБ”) 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмыг баталснаар Монгол улсад байгаль орчин, нийгэм, засаглалын (“БОНЗ”) тайлагналын талаарх зохицуулалт бий болсон байна. Түүнчлэн 2022 оны 8 дугаар сард СЗХ, МХБ болон бусад байгууллагууд хамтран “БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг” боловсруулжээ.

Ийнхүү БОНЗ-ын талаар нийтэд мэдээлэх, тайлагнахыг шаардах болсон нь Монгол дахь бизнесийн практикийг олон улсын стандартад нийцүүлэх, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдэд болон олон нийтэд мэдээллийг илүү ил тод нээлттэй байдлаар хүргэх зорилготой юм.



Хэнд хамааралтай вэ?

✓ БОНЗ-ын талаар олон нийтэд заавал мэдээлэх:

- ✓ Нээлттэй хувьцаат компаниуд
- ✓ Даатгагч
- ✓ Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд
- ✓ Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг компани

✓ БОНЗ-ын талаар сайн дураар мэдээлэх: Кодекст тусгаснаар эдгээрээс бусад компаниуд БОНЗ-ын талаар хуульд заасны дагуу мэдээлэх шаардлагагүй ч сайн дураар мэдээлэх нь зүйтэй.



Юу өөрчлөгдсөн бэ?

1. БОНЗ-ын талаар олон нийтэд заавал мэдээлэх

Кодекст тусгаснаар БОНЗ-ын талаар тайлагнах үүрэг нь харьцангуй хялбар бөгөөд нээлттэй хувьцаат компаниуд болон бусад тодорхой компаниуд өөрсдийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж буйгаа нийтэд мэдээлж, тайлбарлах үүргийг хүлээсэн байна. Түүнчлэн, тус үүрэг болон Кодекст заасан бусад үүргийн хэрэгжилтийг МХБ-д жил бүр тайлагнаж, жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй болсон байна. Цаашлаад, БОНЗ-ын талаар тогтвортой байдлын тайланг тусад нь гаргах боломжтой бөгөөд хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэх тухай Кодекст онцолсон байна.

2. Сайн дураар БОНЗ-ын талаар тайлагнах

Кодексийг мөрдөх үүрэггүй компаниудын хувьд сайн дурын үндсэн дээр БОНЗ-ын тайлан гаргах боломжтой. Хаалттай хувьцаат компани, МХБ-д бүртгэлгүй компаниуд болон бусад байгууллагууд МХБ-ийн журмын Хавсралт 1-т заасан үзүүлэлтийн дагуу тайланг бэлтгэнэ. Тус хавсралтын дагуу БОНЗ-ын тайлан нь тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоо, байгаль орчин, нийгэм, засаглал, болон тухайн салбарын үзүүлэлтүүд гэсэн ерөнхий бүтэцтэй байна.

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.



Юуг тайлагнах вэ?



Байгаль орчин

- ☐ Эрчим хүчний хэрэглээ болон хэмнэлт
- ☐ Хүлэмжийн хийн ялгарал
- ☐ Уур амьсгалын өөрчлөлт
- ☐ Ус
- ☐ Хог хаягдал
- ☐ Биологийн олон янз байдал



Нийгэм

- ☐ Хүний нөөцийн хөгжил
- ☐ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- ☐ Эрх тэгш байдал
- ☐ Хүртээмжтэй орчин, оролцоо
- ☐ Нийгмийн хариуцлага, ил тод байдал
- ☐ Тогтвортой нийлүүлэлтийн удирдлага ханган сүлжээний



Засаглал

- ☐ Авилга, Ёс зүй
- ☐ Компанийн засаглал
- ☐ Комплайнс
- ☐ Хувьцаа эзэмшигчдийн оролцоо

- ☐ БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж болон МХБ-ийн журамд зааснаар эдгээр үзүүлэлтүүдийг заавал тайлагнах ёстой. Түүнчлэн эдгээрээс гадна санхүүгийн, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилгын салбарт тухайн салбарын онцлогтой холбогдуулан харгалзах үзэх ёстой нэмэлт үзүүлэлтүүд бий.
- ☐ Түүнчлэн удирдамжид тусгаснаар компаниуд ТООС, ТБНББСЗ, ОУНТЗ гэх мэт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналыг стандартыг баримтлах нь зүйтэй.



Ямар үр дагавартай вэ?



Кодексийг мөрдөх үүргээ биелүүлээгүй компаниудад Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 20,000,000 төгрөгийн торгууль ногдуулж болзошгүй.



МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу Кодексийг мөрдөхгүй байх нь үнэт цаасны бүртгэлийн ангилал бууруулах үндэслэл болно.



ТА ЭНД ДАРЖ ЭСВЭЛ ДАРААГИЙН ХУУДАСНААС БОНЗ-ТАЙ ХОЛБООТОЙ БИДНИЙ САНАЛ БОЛГОЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАРНА УУ.



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.



Бид хэрхэн туслах вэ?

Татварын
үйлчилгээ

- Татварын бодлогыг тогтвортой байдлын бодлоготой уялдуулахад зөвлөгөө үзүүлэх
- Татварын харилцаа, ил тод байдлын бодлогын зөвлөгөө үзүүлэх
- БОНЗ-д онцгой анхаардаг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид зориулж, татварын удирдлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, үнэлэхэд дэмжлэг үзүүлэх
- БОНЗ-тай холбоотой арга хэмжээний татварын нөлөөг тодорхойлох үзүүлэлт боловсруулах
- БОНЗ-ын хөрөнгө оруулалт, тэнцвэрт байдлын зорилттой (net zero) холбоотойгоор өртгийн хэлхээнд орсон өөрчлөлтөд татварын бүтэц, үнэ шилжилтийн тайлангийн үйлчилгээ
- БОНЗ-ын тайлагналын стандартын дагуу нэгдсэн байдлаар тайлагнахад туслалцаа үзүүлэх
- Татварын хуулийн хэрэгжилтийг технологид суурилсан болгох

Хууль зүйн
үйлчилгээ

- БОНЗ-тай холбоотой бодлого болон бусад баримт бичгийг боловсруулах
- БОНЗ-тай холбоотой байнгын хууль зүйн туслалцаа үзүүлэх
- Ногоон бонд болон бусад үнэт цаас гаргахад хууль зүйн туслалцаа үзүүлэх (Эрсдэлийн удирдлагын хязгаарлалтын хүрээнд)
- БОНЗ-тай холбоотой шинээр нэмэгдсэн болон олон улсын шаардлага зэрэг агуулгыг багтаасан сургалт зохион байгуулах
- БОНЗ-ын комплайнс: Гэрээ, хэлэлцээрийн хяналт, шинжилгээ, нүүрсхүчлийн хий ялгаруулах зөвшөөрлийн трейдинг, эрсдэлийн удирдлага, шүүхийн маргаан
- БОНЗ-ын магадлан шинжилгээ
- Хүний эрхийн магадлан шинжилгээ

Баталгаа-
жуулалтын
үйлчилгээ

- БОНЗ-ын тайлан болон тогтвортой байдлын тайлангийн санхүүгийн бус тайлагналын стандартын дагуу бэлтгэх (ТОУС, ТБНБСЗ, ОУНТЗ гэх мэт).
- БОНЗ-ын тайланд тусгагдсан мэдээллийг баталгаажуулах, нягтлах
- Олон улсын БОНЗ-ын үнэлгээ авахад туслалцаа үзүүлэх (Жишээлбэл, УАӨСМТАХ, ОУДА, гэх мэт.)
- Дотоод хяналтын дүрэм журам, байгууллагын бүтэц зэргийг тодорхойлох
- БОНЗ-ын дижитал шийдлүүд
- Компанийн засаглалын үнэлгээ

Зөвлөх
үйлчилгээ

- Компанийн засаглалд БОНЗ-ын зарчмуудыг тусгах
- Байгаль орчин, олон талт байдал, тэгш байдал болон оролцоо зэргийг хамруулсан, компанийн өсөлт хөгжил, нэр хүндэд эерэг нөлөө үзүүлэхүйц БОНЗ-ын стратегийг боловсруулах
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тэнцвэрт байдалд (net zero) хүргэх стратеги болон түүний хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулахад туслалцаа үзүүлэх
- Ногоон банкны шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх
- Ажлын байран дахь олон талт байдал, тэгш байдал, болон оролцоог нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэх
- БОНЗ-ын олон улсын үнэлгээ рейтинг авахад дэмжлэг үзүүлэх
- БОНЗ-ын магадлан шинжилгээ болон компани нэгтгэх, нийлүүлэх хэлцэлд БОНЗ-тай холбоотой үйлчилгээ үзүүлэх
- Технологид суурилсан БОНЗ-ын тайлагнал, хяналтын тогтолцоо
- Ногоон бонд гаргахад дэмжлэг үзүүлэх



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.